



БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2017/11

www.bulgan.nso.mn



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

www.1212.mn

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.

Monstat ezStat
аппликейшн

1900-1212
Лавлах утас

@statistic_mn

Статистик
мэдээлэл

Үндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН

Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
I. 1 Хүн ам.....	12
I. 2 Хөдөлмөр.....	13
I. 3 Нийгмийн халамж.....	14
I. 3 Нийгмийн даатгал.....	14
I. 4 Эрүүл мэнд	15
I. 6 Гэмт хэрэг	15
II.3 Үнэ.....	17
II.7 Аж үйлдвэр.....	22
II.14 Мал аж ахуй.....	23
II.15 Газар тариалан.....	27

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - 'i' барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - 'i' барааны суурь үеийн үнэ,

q_{io} - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Хүн ам

2017 оны 11-р сарын байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 1113 хүүхэд, нас барсан 331 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 0.8 хувиар, нас баралт 8.7 хувиар тус тус буурчээ.

Зураг I.1.2

Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



11-р сарын байдлаар 858 хүн шилжин ирж, 1022 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 254 буюу 29.6 хувиар, шилжин явсан хүн 316 буюу 30.9 хувиар тус тус буурсан байна. Энэ бууралт нь шилжих хөдөлгөөний бүртгэлийг зогсоосонтой холбоотой байна.

Зураг I.1.3

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн



I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст ажил хайгч иргэн 379 болсны 217 нь эмэгтэй байна. Ажил хайгч иргэдийн 0.5 магистр, докторын, 28.8 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 5.0 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.0 хувийг техникийн болон мэргэжлийн, 53.3 хувийг бүрэн дунд боловсролтой, 5.5 хувийг суурь боловсролтой, 2.1 хувийг бага боловсролтой, 0.8 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.1

Ажлын шинэ байранд болон ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд ажил хайгч иргэдийн 18.2 хувийг 15-24 насны, 39.1 хувийг 25-34 насны, 20.8 хувийг 35-44 насны, 17.7 хувийг 45-54 насны, 2.4 хувийг 55-59 насны, 1.8 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр



I.3. Нийгмийн даатгал, халамж Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны 11-р сарын байдлаар 10896.9 сая төгрөг, зарлага 31788.3 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 407.4 сая төг буюу 3.9 хувиар өсч, зарлага 2071.8 сая төг буюу 7.0 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 407.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэмжийн даатгалын сангийн орлого 107.8 сая.төг буюу 14.9 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 394.8 сая.төг буюу 15.0 хувиар, өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин тэтгэврийн даатгалын сангийн орлого 104.6 сая.төг буюу 1.6 хувиар, буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 2071.8 сая.төг буюу 7.0 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сан 1876.3 сая.төг буюу 7.4 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 116.9 сая.төг 4.4 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 18.8 сая.төг буюу 6.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны 11-р сарын байдлаар 12076 хүн 4303.9 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 33.7 сая.төг буюу 0.8 хувиар өсч харин нийгмийн халамжийн тэтгэвэрт 1209 хүн хамрагдаж 1508.0 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 102.4 сая.төг буюу 6.4 хувиар буурсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2017 оны 11-р сарын байдлаар 6868 хүн хамрагдсаны 23.6 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 22.5 хувь ахмад настан, 4.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 47.1 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 1308.3 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 57.6 сая.төг буюу 4.6 хувиар өссөн байна.




1.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2017 оны 11-р сарын байдлаар 749 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 757 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 66 буюу 8.8 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 49 буюу 6.1 хувиар тус тус буурсан байна.

Зураг 1.4.1


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд,



Нялхасын эндэгдэл 2017 оны 11-р сарын байдлаар 9 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеээс 1 буюу 10 хувиар өссөн байна.

Зураг 1.4.2

Эндсэн хүүхэд



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2017 оны 11-р сарын байдлаар 451 болж, өмнөх оны мөн үеийнхээс 246 тохиолдол буюу 36 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 227 буюу 50.3 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 174 буюу 38.6 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг 1.4.3

Халдварт өвчнөөр өвчлөгсөд




1.6 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2017 оны 11-р сарын байдлаар 353 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 107 хэргээр буюу 43.5 хувиар өссөн байна.

Зураг 1.6.1

Бүртгэгдсэн гэмт хэрэг




Хэргийн өнгөөр нь авч үзвэл

- ХЭМХБЭГХ /ИЭЧЭМЭГХ/ 99 бүртгэгдэж 14 хэргээр буюу 16.4 хувиар
- ХБОЭГХ /БХЖЭГХ/ 22 бүртгэгдэн 18 хэргээр буюу өмнөх оны мөн үеийнхээс 4.5 дахин
- Бусдын амь насыг болгоомжгүй алах гэмт хэрэг 3 бүртгэгдэж 2 дахин
- Хулгайлах гэмт хэрэг 111 бүртгэгдэж 18 хэргээр буюу 19.3 хувиар тус тус өссөн
- Хүнийг санаатай алах гэмт хэрэг 3 бүртгэгдэн өмнөх оны мөн үеэс 4 хэргээр буюу 57.1 хувиар
- Хүчингийн гэмт хэрэг 5 бүртгэгдэж 37.5 хувиар тус тус буурсан
- Мал хулгайлах хэрэг 35
- ХАБЭГХ /ХАБАЖЭГХ/ 26 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Гэмт хэргийн улмаас нийт иргэд , аж ахуй нэгж байгууллагад 1488.3 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 1257 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 506.8 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан .

Зураг I.6.2

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн 11-р сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас 42 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 44.8 хувиар өссөн байна.

Хэргийн өнгөөр нь авч үзвэл: Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас 21, болгоомжгүй хүний амь насыг хохироох гэмт хэргийн улмаас 3, бусдыг санаатай алах гэмт хэргийн улмаас 3, ХАБАЖЭГХ-ийн улмаас 15 иргэн тус тус амь насаа алдсан байна. Гэмт хэргийн улмаас 124 иргэн гэмтсэн нь ИЭЧЭМЭГ хэргийн улмаас 87, ХАБАЖЭГ хэргийн улмаас 26, бусад хэргийн улмаас 11 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4.2 хувиар өссөн байна.

Зураг I.6.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан, жил бүрийн 11-р сарын байдлаар



Захиргааны зөрчлийн талаар

2017 оны 11-р сарын байдлаар 12105 зөрчилд 564.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 496 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 3.1 хувиар буурсан байна. Захиргааны журмаар 103 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 269 иргэн байна.


II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Аймгийн төсөв

Аймгийн төсвийн нийт орлого 2017 оны 11-р сарын байдлаар 48927 сая төгрөг, зарлага 45316 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 3611 сая төгрөгний эерэг гарлаа.

Зураг II.1.1

Аймгийн төсвийн орлого, зарлага сая төг



Орон нутгийн төсвийн орлогын 37.5 хувийг татварын орлого, 4 хувийг татварын бус орлого, 58.3 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Төсвийн зарлага 2017 оны 11-р сарын байдлаар 48927 сая.төг болоход 74.6 хувийг бараа ажил үйлчилгээний зардал, 14.5 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага сараар



Нийт өр 325.2 сая, нийт авлага 46.9 сая төгрөг байна.Цалин, НДШ-ийн өр 146.9 сая, тогтмол зардлын өр 101.9 сая, эмийн өр 25.5 сая, шатахууны өр 12 сая, албан томилолтын өр 11.1 сая, бусад зардлын өр 16.3 сая төгрөг байна.




II.3 Үнэ Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2017 оны 11-р сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 2.0 хувиар, оны эхнээс 1.5 хувиар өсч, харин өмнөх сарынхаас 0.3 хувиар буурсан байна.

Зураг II.3.1

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2016I-XII сар, (өмнөх сар=100%)



Хүснэгт II.3.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2017 XI 2016 XI	2017 XI 2016 XII	2017 XI 2017 X
Ерөнхий индекс	100.0	102.0	101.5	99.7
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	104.9	103.2	98.5
Согтууруулах ундаа, тамхи	3.2	104.9	104.0	100.1
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	98.3	97.3	99.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	102.7	102.4	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	99.7	100.1	101.1
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	103.3	103.3	101.0
Тээвэр	12.2	103.5	103.5	99.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	100.3	100.3	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	100.1	100.1	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	105.4	105.5	101.0

II.4 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2017 оны 11 сарын байдлаар адууны шир 19.5 мян.төгрөг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 22.5 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 35.0 мян.төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны дэл 12.5 хувиар, үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 12.5 хувиар, 2.3 метрээс дээш урттай шир 16.7 хувиар тус тус өссөн бол адууны шир 35 хувиар буурсан байна.

II.5 Малын дундаж үнэ

2017 оны 11 сарын байдлаар тэмээ 900.0 мян.төг, адуу 583.0 мян.төг, үхэр 728.0 мян.төг, хонь 102.0 мян.төг, ямаа 76.0 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс ямаа 7.0 хувь, хонь 5.8, үхэр 8.7 хувь, адуу 6.7 хувь хувиар тус тус буурсан бол тэмээ 12.5 хувиар өссөн байна.


II.6 Аж үйлдвэр

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны эхний 11 сарын байдлаар 2830.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 5681.9 сая төгрөгийн борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 32.2 хувиар, борлуулалт 5.7 хувиар тус тус буурсан байна.

Өмнөх оноос үйлдвэрлэлт 1 дахин буурсан нь Хангайнгурил ХХК, ИНТОСЭ ХХК гурлын үйлдвэрүүд үйлдвэрлэлт байхгүйн улмаас шалтгаалж байна.

Зураг II.6.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт



II.14 Хөдөө аж ахуй

Мал төллөлт, төл бойжилт

Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1573.7 мянган хээлтэгч малын 1295.7 мянга буюу 82.3 хувь нь 2017 оны 11 сарын байдлаар төллөсөн байна. Эм ямааны 83.3 хувь, эм хонины 84.9 хувь, ингэний 50.2 хувь, үнээний 71.8 хувь, гүүний 66.0 хувь төллөжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал ижил хувьтай байна.

Гарсан төлийн 97.2 буюу 1295.7 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.2 пунктээр өссөн байна.

Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2017 оны 11 сарын байдлаар 63.4 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 18.8 мян.толгой мал буюу 42.2 хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 7.2 мянга буюу 11.4 хувь, үхэр 7.6 мянга буюу 12.1 хувь, хонь 30.0 мянга буюу 47.4 хувь, ямаа 18.5 мянга буюу 29.2 хувь буюу оны эхний малын 1.8 хувь нь хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх 76.5 хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Орхон 18.8 хувь, Бүрэгхангай сум 15.4 хувь, Баян-агт сум 9.6 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна. Хорогдсон хээлтэгч 10.2 мянган толгой болж өмнөх оны мөн үеийнхээс 1.9 мянган толгой мал буюу 18.8 хувиар өссөн байна.


Зураг II.14.1

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, 8 сарын байдлаар, толгой



Зураг II.14.2

Том малын зүй бусын хорогдол




II.15 Хөдөө аж ахуй

**Газар тариалан
Тариалсан талбай**

2017 оны байдлаар Аймгийн хэмжээнд нийт 48559.2 га талбайд тариалалт хийсэн байна. Үүнээс үр тариа 42992.7 га, төмс 382.89 га, хүнсний ногоо 146.1 га, техникийн ургамал 4496 га, тэжээлийн ургамал 288 га, эмийн ургамал 253.5 га талбайд тус тус тариалтыг хийжээ.

Зураг II.15.1


Тариалсан талбай /га/



Тариалсан талбай өнгөрсөн оны мөн үеийхээс 16.2 хувиар буюу 6774.1 га-гаар өссөн. Үүнээс: үр тариа 5365.9 га буюу 14.3 хувь, тэжээлийн ургамал 22.4 га буюу 8.4 хувиар, техникийн ургамал 1765 га буюу 64.6 хувиар тус тус өссөн бол эмийн ургамал 152,5 га буюу 37.6 хувиар, хүнсний ногоо 99.89 га буюу 40.6 хувиар, төмс 126.81 га буюу 24.9 хувиар буурсан байна.

Зураг II.15.2

Үр тариа, төмс, хүнсний ногооний тариалсан талбай 2017 оны байдлаар




I.I ХҮН АМ

Хүснэгт I.I.1 Хүн ам, өрх

Сум	Хүн ам		2016/ 2015	Эрэгтэй		2016/ 2015	Эмэгтэй		2016/ 2015	Өрх		2016/ 2015
	2015	2016		2015	2016		2015	2016		2015	2016	
Баян-Агт	3052	3119	102.2	1550	1583	102.1	1502	1536	102.3	890	909	102.1
Баяннуур	1868	1818	97.3	983	969	98.6	885	849	95.9	534	530	99.3
Бугат	2182	2241	102.7	1132	1187	104.9	1050	1054	100.4	797	818	102.6
Булган	12234	12512	102.3	6014	6104	101.5	6220	6408	103.0	3573	3567	99.8
Бүрэгхангай	2726	2832	103.9	1388	1459	105.1	1338	1373	102.6	875	934	106.7
Гурванбулаг	3133	3176	101.4	1617	1644	101.7	1516	1532	101.1	945	948	100.3
Дашинчилэн	2803	2941	104.9	1431	1492	104.3	1372	1449	105.6	848	875	103.2
Могод	2685	2701	100.6	1375	1383	100.6	1310	1318	100.6	835	843	101.0
Орхон	3482	3584	102.9	1865	1911	102.5	1617	1673	103.5	1203	1246	103.6
Рашаант	3141	3165	100.8	1583	1602	101.2	1558	1563	100.3	981	981	100
Сайхан	3575	3648	102.0	1816	1854	102.1	1759	1794	102.0	1092	1111	101.7
Сэлэнгэ	3207	3306	103.1	1666	1723	103.4	1541	1583	102.7	1008	1035	102.7
Тэшиг	3495	3504	100.3	1786	1782	99.8	1709	1722	100.8	946	974	103.0
Хангал	4548	4611	101.4	2282	2302	100.9	2266	2309	101.9	1426	1469	103.0
Хишиг-Өндөр	3154	3156	100.1	1592	1595	100.2	1562	1561	99.9	1045	1035	99.0
Хутаг-өндөр	4729	4835	102.2	2432	2487	102.3	2297	2348	102.2	1481	1516	102.4
Нийт хүн ам	60014	61149	101.9	30512	31077	101.9	29502	30072	101.9	18479	18791	101.7

Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2016 он



I.2 ХӨДӨЛМӨР

Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Үзүүлэлт	2016 I-XI		2017 I-XI		$\frac{2017 \text{ I-XI}}{2016 \text{ I-XI}} \%$	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	962	448	367	227	38.1	50.7
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	723	329	243	155	33.6	47.1
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	542	261	656	283	121.0	108.4
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур	210	87	117	30	55.7	34.5
Уул уурхай олборлолт	28	3	73	6	260.7	200.0
Боловсруулах үйлдвэр	10	4	18	10	180.0	250.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт			10	1		
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1	1	6	5	600.0	500.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл						
Зочид буудал, байр, сууц болон нитийн хоолны үйлчилгээ	2	1	2	1	100.0	100.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	10	8	60	24	600.0	300.0
Боловсрол	9	7	38	27	422.2	385.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	7	7	22	19	314.3	271.4
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа						
Бусад	265	143	310	160	117.0	111.9
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	962	448	367	227	38.1	50.7
15-24	152	67	57	40	37.5	59.7
25-34	337	158	131	80	38.9	50.6
35-44	239	114	92	60	38.5	52.6
45-54	174	87	69	43	39.7	49.4
55-59	45	16	11	1	24.4	6.3
60+	15	6	7	3	46.7	50.0
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	962	448	367	227	38.1	50.7
Магистр, доктор	5	2	1		20.0	0.0
Дипломын болон бакалаврын дээд	154	89	94	71	61.0	79.8
Тусгай мэргэжлийн дунд	44	29	15	10	34.1	34.5
Техникийн болон мэргэжлийн	74	24	10	5	13.5	20.8
Бүрэн дунд	513	239	213	121	41.5	50.6
Суурь	134	55	25	15	18.7	27.3
Бага	31	6	7	5	22.6	83.3

I.3. НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүснэгт I.3.2 Нийгмийн халамжийн зарлага, хамрагдсан хүн

	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2017 I-XI 2016 I-XI
	2016 I-XI	2017 I-XI	2016 I-XI	2017 I-XI	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	9556	12076	4270231.7	4303915.9	100.8
Халамжийн тэтгэвэр	1375	1209	1610491.6	1508051.6	93.6
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	4053	3999	1408994.8	1487523.1	105.6
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	2330	2305	542710.1	539204.3	99.4
Ахмад настныг асарч буй иргэний	924	996	478117.3	562152.4	117.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	496	429	233787.0	229504.3	98.2
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	277	242	141578.6	139370.4	98.4
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	26	27	12801.8	17291.7	135.1
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	4128	6868	1250745.3	1308341.2	104.6
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	1417	1546	260740.5	278206.4	106.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	346	332	78165.7	107964.7	138.1
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	2201	1622	608457.9	599133.2	98.5
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	45	12	11500.0	2000.0	0.0
Хүнс тэжээл хөтөлбөр		3,237	274111.5	302905.7	110.5
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ	119	119	17769.7	18131.2	102.0

I.3. НИЙГМИЙН ДААТГАЛ

Үзүүлэлтүүд	2015 I-XI	2016 I-XI	2017 I-XI	2017 XI 2016 XI
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	9129.8	10489.5	10896.9	103.9
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	6013.9	6468.5	6363.9	98.4
Тэтгэмжийн даатгалын сан	681.8	725.7	833.5	114.9
Эрүүл мэндийн даатгалын сан	1833.1	2624.6	3019.4	115.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	438.9	498.8	506.3	101.5
Ажилгүйдлийн даатгалын сан	162.1	171.9	173.8	101.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	26230.8	29716.5	31788.3	107.0
Үүнээс:				
Тэтгэврийн даатгалын сан	22793.5	25288.9	27165.2	107.4
Тэтгэмжийн даатгалын сан	971.7	1005.5	1048.9	104.3
Эрүүл мэндийн даатгалын сан	1895.1	2666	2782.9	104.4
ҮОМШӨ*-ний даатгалын сан	406.1	444.9	461.3	103.7
Ажилгүйдлийн даатгалын сан	164.4	311.2	330.0	106.0

I.4 ЭРҮҮЛ МЭНД

Хүснэгт I.4.1 Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр оноор

Үзүүлэлт	2015 I-XI	2016 I-XI	2017 I-XI	2017/2016
Амаржсан эхийн тоо	913	803	749	93%
Амьд төрсөн хүүхэд	920	806	757	94%
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Амьгүй төрөлт	3	6	0	0%
Гэрийн төрөлт	6	3	5	167%
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	17	10	9	90%
Перинаталь эндэгдэл	15	10	6	60%
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	19.9	12.4	11.9	96%

Хүснэгт I.4.2 Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, оноор

Үзүүлэлт	2015 I-XI	2016 I-XI	2017 I-XI	2017/2016
Нийт гарсан халдварт өвчин	373	697	451	65%
Гэдэсний халдварт өвчин	11	4	5	-
Амьсгалын замын халдварт өвчин	134	479	227	47%
Байгалын голомтот халдварт өвчин	1	10	16	-
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	205	175	174	99%
Арьсны халдварт өвчин	24	33	31	94%

I.5 ГЭМТ ХЭРЭГ

Хүснэгт I.4.1 Бүртгээгдсэн гэмт хэрэг, оноор, 11-р сарын байдлаар

Сум	2013 I-XI	2014 I-XI	2015 I-XI	2016 I-XI	2017 I-XI	2017 I-XI % 2016 I-XI
Булган	99	77	54	74	81	109.5
Баян-Агт	12	22	12	10	9	90.0
Баяннуур	7	9	11	6	8	133.3
Бугат	20	16	19	16	27	168.8
Бүрэгхангай	15	15	21	14	19	135.7
Гурванбулаг	18	17	11	10	12	120.0
Дашинчилэн	9	15	19	12	9	75.0
Могод	18	8	9	12	8	66.7
Орхон	32	26	35	22	44	200.0
Рашаант	15	13	17	7	14	200.0
Сайхан	23	17	8	13	15	115.4
Сэлэнгэ	14	13	9	4	22	550.0
Тэшиг	17	7	5	10	11	110.0
Хангал	18	16	4	5	24	480.0
Хишиг-Өндөр	17	16	21	8	19	237.5
Хутаг-Өндөр	23	21	8	22	23	104.5
Хялганат	10	10	9	1	8	800.0
Бүгд	367	318	272	246	353	143.5

Хүснэгт 1.4.2 Хулгайн гэмт хэрэг, сумаар, оноор, 11-р сарын байдлаар

Сум	2013 I-XI	2014 I-XI	2015 I-XI	2016 I-XI	2017 I-XI
Булган	30	18	15	25	33
Баян-Агт	5	19	3	4	4
Баяннуур	6	7	8	4	2
Бугат	10	6	4	6	8
Бүрэгхангай	7	5	10	5	3
Гурванбулаг	5	7	3	3	4
Дашинчилэн	5	6	11	5	2
Могод	9	4	1	9	2
Орхон	15	13	17	12	17
Рашаант	6	9	7	3	3
Сайхан	17	14	2	4	9
Сэлэнгэ	9	5	1	1	6
Тэшиг	11	2	2	1	1
Хангал	3	2			3
Хишиг-Өндөр	7	9	6	4	5
Хутаг-Өндөр	14	6	2	7	8
Хялганат	2	4	1		1
Бүгд	161	136	93	93	111

Хүснэгт 1.4.3 Сумдын хэргийн илрүүлэлт 2017 оны 11-р сарын байдлаар

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг	Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг	Хэргийн илрүүлэлтийн хувь
Булган	34	11	32.4
Баян-Агт	5	3	60.0
Баяннуур	2	1	50.0
Бугат	9	4	44.4
Бүрэгхангай	8	3	37.5
Гурванбулаг	5	3	60.0
Дашинчилэн	2	1	50.0
Могод	2		0.0
Орхон	18	6	33.3
Рашаант	8	5	62.5
Сайхан	9	6	66.7
Сэлэнгэ	10	5	50.0
Тэшиг	3	0	0.0
Хангал	4	2	50.0
Хишиг-Өндөр	6	4	66.7
Хутаг-Өндөр	7	2	28.6
Хялганат	4	2	50.0
Бүгд	136	58	42.6

Хүснэгт I.4.4 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, оноор, 11-р сарын байдлаар

Үзүүлэлт	2013 I-XI	2014 I-XI	2015 I-XI	2016 I-XI	2017 I-XI	2017 I-XI% 2016 I-XI
	сая төгрөг					
Учирсан хохирол- Бүгд	810	753.5	679.9	543.2	1314.4	211%
Үүнээс						
